



EPCRC  
ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS  
RESEARCH CENTER  
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГ, ӨРСӨЛДӨХ  
ЧАДВАРЫН СУДАЛГАНЫ ТӨВ

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2024/9

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.IX	2023.IX	2024.VIII	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	16.4	13.6	-	-	-	-	5.6% ▲
Инфляц	хувь	6.7	10.1	6.5	0.1% ▲	-	5.3% ▲	-3.4 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	5.8% 2024 оны У2	5.6% 2023 оны У2	-	-	0.7% ▲ нэгж хувиар	-	0.2 нэгж хувиар ▲
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1469	2158	1572	-103 ▼	-	-	-689 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3380.95	3466.08	3380.98	-0.03 ▼	-	-	-85 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3174.4	4540.7	3123.5	51 ▲	-	-	-1366 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	59.1	48.9	53.7	-	-	-	10.2 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1186.4	1151.3	1039.2	-	-	-	35.1
Төв банкны бодлогын хүү	хувь	10%	13%	11%	-1%	-	0%	-3%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.6	4.1	4.7	-0.88% ▼	-	-	13.5% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.63%	8.43%	5.73%	-0.1 нэгж хувиар ▼	-	-	-2.8 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөлөл 2024-III	2024 оны III улиралд эдийн засгийн өсөлт 5.9 хувь, зээлийн хүүг бага зэрэг буурахаар төсөөлсөн бол 2025 оны II улиралд Инфляц нэмэгдэж 7.0%, Эдийн засгийн өсөлт 6.0%, Бодлогын хүү 10.7%, Зээлийн хүү бага зэрэг буурч 16.1% болно гэж таамагласан байна. <a href="https://www.mongolbank.mn/mn/research/1268">https://www.mongolbank.mn/mn/research/1268</a>
---------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монголбанк бодлогын хүүг 1 нэгж хувиар буурууллаа.	2024/09/13	Инфляц зорилтот интервалд тогтворжихоор байгаа тул санхүүгийн нөхцөлийг сулруулж, дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргалаа.



[www.facebook.com/ecrcmn](https://www.facebook.com/ecrcmn)



[www.twitter.com/ursulduhchadvar](https://www.twitter.com/ursulduhchadvar)



[www.instagram.com/ecrcmn](https://www.instagram.com/ecrcmn)



[www.ecrc.mn](https://www.ecrc.mn)




976-11- 321927

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард 10.1 хувь байсан бол 2024 оны 9 дүгээр сард 6.7 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурсан байна. Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 2.3 нэгж хувиар (34.1%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 3.3 нэгж хувиар (49.1%) тус тус нөлөөлсөн байна.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 9 дугаар сард 3380.95 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 85 төгрөгөөр, өмнөх сараас 0.03 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -0.88%-р буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 13.05%-р өсөж, 4.66 тэрбум ам.долларт хүрэв.

#### Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 22.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.1 (28.9%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 21.3 их наяд төгрөгт хүрч, 4.4 (25.9%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 9 сард 19.8 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 9 сард нийт 154 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 20.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 11.8 тэрбум ам.доллар, импорт 8.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.3 (13.0%) тэрбум ам.доллар, экспорт 482.7 (4.3%) сая ам.доллар, импорт 1.9 (27.5%) тэрбум ам.доллароор тус тус өсөж, тэнцэл 1.4 (30.2%) тэрбум ам.доллароор буурсан байна.

#### Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 9-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, -р сар 2024 он, Монголбанк](#)
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)